

ХУГАЦАА: 60

НИЙТ- 24 ОНОО

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: 1. Эхийг анхааралтай уншиж, ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Гэмшил

Дондог хүү гудамжнаас хөөрхөн халтар гөлөг тэврээд иржээ. Хүү хөлд орохоосоо л гөлгөнд дуртай хүүхэд байж. Ээж нь хүүгийнхээ сэтгэлийг бодоод “Хүү минь гараа л сайн угааж, хоол ундаа иддэг юм шүү” гэжээ. Дондог зав л гарвал гөлөгтэйгөө тоглож, орон дээрээ гарган эрхлүүлж, оровч, гаравч дагуулна. Ингээд бүр аягатай хоол хувааж иддэг болов.

Ээж нь сэтгэл зовж, гөлгийг эзэнд нь өгнө шүү гэв. Тэгснээ: - Хүү минь нохойтой бүү тогло, өвчин халдварлана гэж учирлана.

-За ээж ээ, нохойтой тоглохгүй ээ, гараа угааж хоолоо иднэ гэж Дондог өгүүлнэ.

Ээжийгээ ажилд явмагц амласнаа мартаад гөлөгнийхөө ам, хамрыг гараараа илж тоглоно. Тэгтэл нэг өдөр толгой нь өвдөн, үе үе огиулан, хоол идэх дургүй болжээ. Ээж нь хүүгээ эмчид үзүүлжээ.

Эмч цээжийг нь чагнаснаа: - Хүү минь гараа харуул гэлээ. Гар нь хиртэй байв. – Хүү минь нохойтой бүү тогло, хоол унд идэхийн өмнө гараа савандаж бүлээн усаар сайн угаа, тэгвэл ер өвдөхгүй. Хүүд бохир гарын өвчин хүрчээ. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ гэж эмч өгүүлэв.

Ээжийнхээ үгэнд орж гараа сайн угаасан бол ийм муухай өвчнөөр өвдөхгүй дээ гэж Дондог бодон ихэд гэмшин уйллаа. Тэгвэл эмч: - Хүү минь тайвшир. Гэм нь урдаа, гэмшил нь хойноо гэдэг юм. Нохойтой бүү тогло, гараа тогтмол угааж бай, мөдхөн эдгэнэ гэлээ. Дондог хүү хориод хоног эмнэлэгт хэвтээд гарчээ.

Тэрбээр нохойд ойртохоо байж, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон юм.

1.1 Хүү гудамжнаас юу олсон бэ? \ 1 оноо \

- А. Бөмбөг Б. Гөлөг В. Тоглоом Г. Саван

1.2 Дондог хүү ээжийгээ ажилдаа явмагц зав л гарвал яадаг байсан бэ? \ 1 оноо \

- А. Хоолоо хийж иддэг В. Хичээлээ тогтмол хийдэг
Б. Гараа тогтмол угаадаг Г. Гөлөгтэйгөө тоглодог

1.3 Хүүг хэн гэдэг байсан бэ?

- А. Дандар Б. Дондог В. Долгор Г. Дорж

1.4 Анхааруулах өгүүлбэрийн төгсгөлд ямар тэмдэг тавьдаг вэ? | 1 оноо \

- А. ? б. ! в. : г. *

1.5 Дараах үгнээс “ийг” залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай \1 оноо \

- А. сансар Б. бодлого В. шавж Г. тосгон

1.6. “Ж, Ч, Ш”-ийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой. / 1 оноо/

- А. гортиг Б. сонин В. хачин Г. морил

1.7 Хоолойн Г орсон бүлэг үгсийг олж дугуйлаарай. \ 1 оноо \

- А. Ганзага, нутаг, торго
Б. Тараг, хурга, булаг
В. Торог, будаг, хоног
Г. Булга, дорго, ботго

1.8 Урья гэсэн үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой. \ 1 оноо \

- А. Урья Б. Уяя В. зорьё Г. очьё

1.9. “Амаа барих” хэлц үгийн утгад тохирохыг нь сонгоорой. \1 оноо \

- А. Алдаагаа засах Б. Ойлгох В. Гэмших Г. Ярихгүй байх

1.10 Дараах үгийн эсрэг утгыг нэрлэсэн үгийг олоорой. \ 1 оноо \

Шалмаг-

- А. Хурдан Б. Удаан В. Онцгой Г. Хэрсүү

Б хувилбар

4..... ангийн сурагч

ХУГАЦАА: 60

НИЙТ- 24 ОНОО

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: УНШИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

САНАМЖ: 1. Эхийг анхааралтай уншиж, ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгээрэй.

Гэмшил

Дондог хүү гудамжнаас хөөрхөн халтар гөлөг тэврээд иржээ. Хүү хөлд орохоосоо л гөлгөнд дуртай хүүхэд байж. Ээж нь хүүгийнхээ сэтгэлийг бодоод “Хүү минь гараа л сайн угааж, хоол ундаа иддэг юм шүү” гэжээ. Дондог зав л гарвал гөлөгтэйгөө тоглож, орон дээрээ гарган эрхлүүлж, оровч, гаравч дагуулна. Ингээд бүр аягатай хоол хувааж иддэг болов.

Ээж нь сэтгэл зовж, гөлгийг эзэнд нь өгнө шүү гэв. Тэгснээ: - Хүү минь нохойтой бүү тогло, өвчин халдварлана гэж учирлана.

-За ээж ээ, нохойтой тоглохгүй ээ, гараа угааж хоолоо иднэ гэж Дондог өгүүлнэ.

Ээжийгээ ажилд явмагц амласнаа мартаад гөлөгнийхөө ам, хамрыг гараараа илж тоглоно. Тэгтэл нэг өдөр толгой нь өвдөн, үе үе огиулан, хоол идэх дургүй болжээ. Ээж нь хүүгээ эмчид үзүүлжээ.

Эмч цээжийг нь чагнаснаа: - Хүү минь гараа харуул гэлээ. Гар нь хиртэй байв. – Хүү минь нохойтой бүү тогло, хоол унд идэхийн өмнө гараа савандаж бүлээн усаар сайн угаа, тэгвэл ер өвдөхгүй. Хүүд бохир гарын өвчин хүрчээ. Одоо эмнэлэгт хэвтэж эмчлүүлнэ гэж эмч өгүүлэв.

Ээжийнхээ үгэнд орж гараа сайн угаасан бол ийм муухай өвчнөөр өвдөхгүй дээ гэж Дондог бодон ихэд гэмшин уйллаа. Тэгвэл эмч: - Хүү минь тайвшир. Гэм нь урдаа, гэмшил нь хойноо гэдэг юм. Нохойтой бүү тогло, гараа тогтмол угааж бай, мөдхөн эдгэнэ гэлээ. Дондог хүү хориод хоног эмнэлэгт хэвтээд гарчээ.

Тэрбээр нохойд ойртохоо байж, хоол унд идэхийн өмнө гараа савантай бүлээн усаар тогтмол угаадаг болсон юм.

- 1.1 Хүү гудамжнаас юу олсон бэ? \1 оноо \
А. Бөмбөг б. саван в. Тоглоом г. Гөлөг
- 1.2. Дондог хүү ээжийгээ ажилдаа явмагц зав л гарвал яадаг байсан бэ? \1 оноо \
А. Хоолоо хийж иддэг в. Хичээлээ тогтмол хийдэг
Б. Гараа тогтмол угаадаг г. Гөлөгтэйгөө тоглодог
- 1.3. Хүү ямар өвчин туссан бэ?
А. Ханиад
Б. Салхин цэцэг
В. Бохир гарын өвчин
Г. Нүдний өвчин
- 1.4. Асуух өгүүлбэрийн төгсгөлд ямар тэмдэг тавьдаг вэ? \1 оноо\
А. ? б. ! в. : г. *
- 1.5 Дараах үгнээс “ийг” залгаврыг залгах үгийг олж дугуйлаарай. \ 1 оноо \
А. горхи Б. Самбар В. шалгуур Г. тосгон
- 1.6. “Ж, Ч, Ш”-ийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой. / 1 оноо/
А. тамир Б. чимээ В. ширдэг Г. хашир
- 1.7 Хэлний үзүүрийн Н орсон бүлэг үгсийг олж дугуйлаарай. / 1 оноо /
А. Хувин, шарна, хонон
Б. харна, өгнө, саван
В. гарна, солино, өрнө
Г. шон, хэн, хачин
- 1.8 Таръя гэсэн үгтэй ижил дүрмээр бичигдсэн үгийг олоорой. \ 1 оноо \
А. Уръя Б. Уяя В. зорьё Г. Бооё
- 1.9 “Амаа барих” хэлц үгийн утгад тохирохыг нь сонгоорой. \ 1 оноо \
А. Гэмших б. Ярихгүй байх в. Алдаагаа засах г. Ойлгох
- 1.10 Дараах үгийн ойролцоо утгыг нэрлэсэн үгийг олоорой. \ 1 оноо \
Эрэн -
А. Цулгай Б. Хар В. Цагаан Г. Алаг

№	Суралцахуйн зорилт	Танин мэдэхүйн түвшин	Зөв хариулт Хувилбар А	Зөв хариулт Хувилбар Б	Оноо	Онооны тайлбар
Монгол хэл						
1	4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	Б	Г	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
2	4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	Мэдлэг ойлголт	Г	Г	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
3	4.1.в Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	Мэдлэг ойлголт	Б	В	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
4		Чадвар	Б	А	1	
5	4.2.в ж,ч,ш-ийн дараа “ий” бичдэгийн учрыг мэдэх, зөв бичих	Чадвар	В	А	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
6		Мэдлэг ойлголт	В	Г	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
7	4.2б. Балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх үүргийг мэдэх, зөв бичих	Чадвар	Г	В	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
8	4.4.в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Хэл зүй	В	А	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
9	4.4.г. эх өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Хэлзүй	Г	Б	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
10	4.4.в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	Хэлзүй	Б	Г	1	Зөв хариулт сонгосон бол 1 оноо
2.1	4.2.а Дуудлага ижил зарим үгийг утга бичлэгээр нь ялгаж өгүүлбэрт зөв хэрэглэх	чадвар	Булга сор Булаг шанд	Гэрийн өрх Тоглоом өрөх	2	Хариулт тус бүр 1 оноо Нийт 2 оноо
2.2	4.2.б балархай эгшгийн эгшигжүүлэх, зөөлрүүлэх, үүргийг мэдэх, зөв бичих	чадвар	1В, 2Б, 3А	1А, 2Б, 3В	3	Хариулт тус бүр 1 оноо Нийт 3 оноо
2.2	4.4.г. Эх, өгүүлбэр зохиохдоо хэлц үгийг утгаар нь зөв хэрэглэх	Хэлзүй	Харамлах	Баярлах	2	Үгийн утгыг зөв тайлбарласан бол 1 оноо Хэлц үгийг өгүүлбэр болгон бичсэн бол 1 оноо
2.3	4.4.а харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд, зэрэг холбох үгсийг хэрэглэн өгүүлбэр эх зохиох	Хэлзүй	1б, 2а	1б, 2а	2	Зөв харгалзуулсан бол тус бүр 1 оноо Нийт 2 оноо
2.4	4.2.ж Бусдыг сайн сайханд зүйлд уриалж, бүтцийн дагуу уриалга бичих	Бичих			5	Бүтцийн дагуу бичсэн бол 3 оноо Үгийн тоо бүрэн бол 2 оноо Алдаа бүр 0.1 оноо

